

БАТЛАВ.
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ИТГЭЛСҮРЭН

ТЭТГЭВРИЙН БОЛОН ДААТГАЛЫН САНГУУДЫН СУУРЬ СУДАЛГАА
ГҮЙЦЭТГЭХ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 04 дүгээр сарын 07

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан.

Тус төлөвлөгөөний Зорилт 5.1-ийн эхний хэсэгт тэтгэврийн болон даатгалын сангуудын эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх ажил тусгагдсан. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Монгол Улсын 2017 оны Харилцан үнэлгээний тайланд энэ чиглэлийн эрсдэлийн үнэлгээ хийгдэж байгаагүй талаар олон удаа дурдагдсан байдаг.

ФАТФ-аас хийгдэх ээлжит харилцан үнэлгээнд бэлтгэх хүрээнд тэтгэврийн болон даатгалын сангуудын эрх зүйн орчин, олон улсад үүсгэн байгуулагдсан тэтгэврийн болон даатгалын сангууд Монгол Улсад үйлчилгээ явуулдаг эсэх зэрэг энэ төрлийн үйлчилгээ үзүүлдэг этгээдтэй холбоотой мэдээллийг цуглуулж, суурь судалгааг гүйцэтгэх шаардлагатай.

ХОЁР. АЖЛЫН ЗОРИЛГО

Энэхүү ажил үйлчилгээ (мэдээлэл цуглуулах, судалгаа гүйцэтгэх)-ний зорилго нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийн хүрээнд батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г үр дүнтэй хэрэгжүүлж, ФАТФ-аас хийгдэх ээлжит харилцан үнэлгээнд бэлтгэхэд оршино.

ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Тэтгэврийн болон даатгалын сангуудын дата мэдээллийг цуглуулж холбогдох судалгааг гүйцэтгэнэ. Үүнд:

№	Ажлын нэр, төрөл даалгавар	Ажлын даалгавар, тавигдах шаардлага
1	Даалгавар: Дата мэдээлэл цуглуулах, суурь судалгаа гүйцэтгэх	Монгол Улсын тэтгэвэр болон даатгалын сангуудын талаарх холбогдох дата мэдээллийг цуглуулах. Энэхүү дата мэдээллийг цуглуулахад ФАТФ-ын тэтгэвэр болон даатгалын сангуудын тодорхойлолт, нийгмийн болон тэтгэврийн даатгалын сангийн тухай хуулийн тодорхойлолтуудыг уялдуулж дата мэдээллийг цуглуулах. Цуглуулсан дата мэдээлэлд үндэслэн тэтгэврийн болон даатгалын эрх зүйн орчны тухай дэлгэрэнгүй судалгааг хийж гүйцэтгэхээс гадна ФАТФ-ын тодорхойлолтод тусгагдсан тэтгэвэр, хуримтлалын тэтгэвэр эсвэл тэтгэвэрт гарсны дараа төлбөр төлөх ижил төстэй тогтолцоо нь цалингаас суутгал хийх зарчмаар хэрэгждэг эсэх, төлбөрийг урьдчилан хуваарилахыг зөвшөөрдөг эсэх, олон улсад байгуулагдсан тэтгэвэр болон даатгалын сангуудын зохицуулалт зэрэг ФАТФ-ын аргачлал болон Монгол Улсын 2017 оны Харилцан үнэлгээнд тусгагдсан асуудлуудын хүрээнд сүүлийн 3 жилийн дэлгэрэнгүй нарийвчилсан судалгааг гүйцэтгэх. Ингэхдээ олон улсын болон дотоодын даатгалын сан, тэтгэврийн сангийн тогтолцооны онцлог, эрх зүй болон соёлын төсөөтэй байдлыг харьцуулсан судалгааг хийнэ.
2	Хүлээгдэж буй үр дүн	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 Зөвлөмжийн хүрээнд Монгол Улс дахь тэтгэврийн болон даатгалын сангуудын эрх зүйн орчин, тоо баримт, санхүүгийн салбарын активт эзлэх хувь, зэргийг цуглуулж ялангуяа тус сангууд нь МУТСТ чиг үүргээс чөлөөлөхүйц бага эрсдэлтэй эсэхийг тодруулж нарийвчилсан судалгааг гүйцэтгэх шаардлагатай. Түүнчлэн энэхүү судалгаа нь олон улсын болон Монгол улсын тэтгэврийн сан, даатгалын сангийн тогтолцооны онцлог, ялгаатай байдлыг дэлгэрэнгүй байдлаар харьцуулан тайлбарласан байна.
3	Хуулийн этгээдэд тавигдах шаардлага	Олон улсын стандарт болон Монгол Улсын хууль эрх зүйн орчны хүрээнд санхүүгийн салбарт судалгаа, шинжилгээ хийсэн туршлагатай байх.
4	Хяналт, гүйцэтгэл	Хуулийн этгээд нь Санхүүгийн зохицуулах хороотой ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажиллах ба ажлын гүйцэтгэлээ Хяналт шалгалт, зохицуулалтын газрын даргад тайлагнана. Ажлын гүйцэтгэлийг тооцоход дараах шаардлага тавигдана. Үүнд:

		<ul style="list-style-type: none"> - Гэрээнд заасан хугацаанд судалгааны тайланг цуглуулсан мэдээлэлд үндэслэн бэлтгэсэн байх; - Мэдээлэл цуглуулсан эх үүсвэр нь тодорхой, баталгаатай байх; - Гүйцэтгэсэн судалгааны тайлан нь үг хэллэг, утга зүйн хувьд чанарын шаардлага хангасан байх; - Гүйцэтгэсэн судалгааны хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох албан хаагчдад сургалт орох; - Гэрээнд заасан ажил хийгдэж дууссаны дараа холбогдох ажлыг бүрэн хийсэн гэж үзвэл захиалагч талд ажлаа тайлагнана; - Тэтгэврийн болон даатгалын сангуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэх ажлын хэсэгт судалгааны дэлгэрэнгүй үр дүнг танилцуулж, сургалт орох.
5	Хугацаа	2025 оны 08 дугаар сарын 25.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО